

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны 08 дугаар сарын
19 -ны өдөр

Дугаар A/292, A/525

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, 8.1.13 дахь заалт, Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн хуралдааны 45 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ыг нэгдүгээр, “Коронавируст халдварт /КОВИД-19/-ын үед ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалт зохион байгуулахад мөрдөх түр журам”-ыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн 2021-2022 оны хичээлийн жилийг эхлүүлэх бэлтгэл хангахтай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох нэгж, байгууллага, албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай:

2.1. Энэ тушаалын нэг дэх хэсэгт заасан журмыг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулж, бэлэн байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Тусгай хэрэгцээт боловсролын хэлтэс /Ч.Ганцэцэг/, аймаг, нийслэлийн Боловсролын газарт;

2.2. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцагчийн сурлагын хоцрогдол нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамжийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/, аймаг, нийслэлийн Боловсролын газарт;

2.3. Сургалтын байгууллагын орчинд коронавируст халдварт (КОВИД-19)-ын тандалт, судалгаа хийх, хариу арга хэмжээ авах чиглэлээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн эмч нарыг давтан бэлтгэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн тусlamжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газар /Л.Энхсайхан/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт;

2.4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль орчмын бүсэд эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг хичээлийн жил эхлэхээс өмнө зохион байгуулж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

2.5. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчинд цэвэрлэгээ, халдвартайжүүлэлт хийх бодист шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж бэлэн байдлыг хангахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

2.6. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ эрүүл мэндийг өдөр тутам ажиглаж, коронавируст халдварт /КОВИД-19/-ын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан багшид мэдээлэл өгөх гар утасны аппликэйшн хөгжүүлж 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дүнжиннамдаг/, Эрүүл мэндийн яамны Мэдээллийн технологийн хэлтэс /Б.Цэрэн-Очир/-т.

3. Энэ тушаалаар батлагдсан журмыг хичээл, сургалтын үйл ажиллагаа хэвийн горимд шилжих хүртэл хугацаанд өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Эрүүл мэндийн дэд сайд М.Баттувшинд тус тус даалгасугай.



Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Эрүүл мэндийн сайдын 2021 оны
08 дугаар сарын 19..-ний өдрийн
A/292, A/325.. дугаар хамтарсан
тушаалын нэгдүгээр хавсралт

**“КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19-/ЫН ҮЕД ЦЭЦЭРЛЭГИЙН
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
МӨРДӨХ ТҮР ЖУРАМ”**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэ журмын зорилго нь коронавируст халдварт (КОВИД-19)-ын тархалтын түвшинтэй уялдуулан хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/-ийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах, халдвараас сэргийлэх бэлэн байдлыг хангах, цэцэрлэгийн орчинд халдвартын сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдэх үед хариу арга хэмжээ авахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг танхимаар зохион байгуулахад Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”, эрүүл мэндийн байгууллагаас гаргасан коронавируст халдвартын үед мөрдөх заавар, зөвлөмж болон энэхүү түр журмыг тус тус баримтална.

1.3. Сургалт, үйл ажиллагааг танхимаар зохион байгуулахад халдвараас сэргийлэх дэглэмийг чанд сахих, боловсролын үйлчилгээ тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах, багш, ажилтан, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч өөр хоорондоо харилцан хүндэтгэлтэй, эелдэг харилцах болон байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн нууцлалыг хадгалах зарчим баримтална.

1.4. Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

Хоёр. Сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Коронавируст халдвартын тархалтын түвшнээс хамаарч цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг танхим болон танхимиын бус (зайн) хэлбэрээр тус тус зохион байгуулна.

2.2. Энэ журмын 2.1-д заасныг хэрэгжүүлэхэд цэцэрлэгийн орчинд дараах тохиолдолд танхимиын сургалтыг зогсоож, 7 хоногийн хугацаатай зайн сургалтад шилжинэ.

2.2.1. тухайн нэг бүлгээс халдвартын тохиолдол батлагдсан нөхцөлд тухайн бүлгийг;

2.2.2. ангийн байрлалаас хамаарч тухайн давхар, жигүүрийн 3 хүртэл бүлэгт халдвартын тохиолдол батлагдсан нөхцөлд тухайн давхар, жигүүрийн бүлгүүдийг;

2.2.3. өөр хоорондоо хамааралгүй (нэг жигүүр, нэг давхар биш, анги болон багш солигддоггүй) 3 ба түүнээс дээш бүлгийн дотор халдвартын тохиолдол батлагдсан нөхцөлд цэцэрлэгийн бүх бүлгийг.

2.3. Зайн сургалтыг хүүхдийн чадварын хоцрогдлыг илрүүлэн, цогц хөгжлийг тасралтгүй дэмжихэд эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллахад чиглүүлнэ.

2.3.1. цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зайн сургалт зохион байгуулах орчин, нөхцөлийг бүрдүүлж, багшид дэмжлэг үзүүлнэ.

2.4 Энэ журмын 2.1-д заасан сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Боловсролын хүрээлэнгээс боловсруулсан арга зүйн зөвлөмж, аймаг нийслэлийн боловсролын газрын мэргэжил, арга зүйн удирдамж, чиглэлийн дагуу төлөвлөж, зохион байгуулна.

2.5. Цэцэрлэгийн үйл ажиллагааны үргэлжлэх хугацаа 8-10 цаг байна.

2.6. Цэцэрлэг өдрийн дэглэмийг онцгой нөхцөл байдалд нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлнэ.

2.7. Цэцэрлэгийн бүлгийн өрөөний нэг хүүхдэд ногдох талбайг $1,5 \text{ m}^2$ -аас доошгүй байхаар тооцож, 20 ± 5 хүүхэд хүлээн авна.

2.7.1. төрийн өмчийн цэцэрлэгийн нэг бүлэгт байх хүүхдийн тоо 25-аас хэтэрсэн тохиолдолд ойр байрлах бусад төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгт тухайн хүүхдийг шилжүүлэн хамруулах зохицуулалт хийж болно.

2.8. Цэцэрлэгт 5 настай хүүхдийг бүрэн, өмнөх хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдсан 4 настай хүүхдийг үргэлжлүүлэн хүлээн авах ба 2, 3 настай хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтыг гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгт тулгуурлан зохион байгуулна.

2.9. Цэцэрлэгийн танхимын сургалтад хамрагдах хүүхдийг тэдний эцэг эх, асран хамгаалагчийн саналыг харгалзан хүлээн авна.

2.9.1. эцэг эх, асран хамгаалагч цэцэрлэгийн танхимын сургалтад 5 настай хүүхдээ хамруулахаас татгалзах тохиолдолд тусгайлан гэрээ байгуулж, зайн сургалтад хамруулан хүүхдийнхээ хөгжлийг дэмжих, багштай эргэх холбоотой ажиллах талаар зөвлөгөө өгнө.

2.9.2. цэцэрлэгийн үндсэн бүлэгт хамрагдах боломжгүй 5 настай хүүхдийг хувилбарт сургалтад хамруулна.

2.10. Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийг дэмжих ганцаарчилсан сургалтыг тэдний онцлог, хэрэгцээнд нийцүүлэн, эцэг эх, асран хамгаалагч зөвшөөрсөн тохиолдолд танхимын сургалтад хамруулна.

2.10.1. энэ журмын 2.10-д заасан сургалтыг зохион байгуулахад хүүхэдтэй ойрын зайнаас харилцах шаардлагатай тохиолдолд багш, ажилтан ам/нүүрний хаалт, нэг удаагийн бээлий заавал хэрэглэх бөгөөд тэдгээрийг тухай бүр солино.

2.10.2. сургалт, үйл ажиллагааны явцад хүүхдийн онцлог, хэрэгцээнээс хамаарч нүүрний хувирал, ам, уруулын хөдөлгөөнөөр харуулах тохиолдолд багш амны хаалтыг авч, нүүрний хаалт хэрэглэж болно.

2.11. Цэцэрлэгийн байранд бөөгнөрөл үүсэхээс сэргийлж, хүүхэд хүлээн авах, тарах цагийг уян хатан байлгах, цэцэрлэгийн байранд орох, гарах боломжит бүх хаалгыг ашиглах зохицуулалт хийнэ.

2.12. Онцгой нөхцөл байдалд ажиллах үед багш, ажилтны ажлын чиг үүрэг, харилцаа, хандлага, ёс зүйн хэм хэмжээнд баримтлах дэгийг нарийвчлан тогтоож, цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар баталж мөрдөнө.

2.13. Сургалт, үйл ажиллагааны явцад хүүхэд, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндэд анхаарч, зовуурь, шинж тэмдэг илрэх тохиолдолд багш цэцэрлэгийн эмчид, эмчгүй тохиолдолд халдвараас сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах багийн түр тусгаарлах өрөө хариуцсан ажилтанд яаралтай мэдэгдэнэ.

2.14. Хүн ам ихээр цуглардаг талбай, үйлчилгээний газарт аялал зугаалга зохион байгуулахгүй.

2.15. Хүүхэд, багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан аливаа уралдаан, тэмцээнийг зохион байгуулахгүй.

2.16. Эцэг эх, асран хамгаалагчаар бэлтгүүлэх ариун цэврийн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан жагсаалтын дагуу З сард хэрэглэгдэх хэмжээгээр бэлтгүүлэн авч, халдвартгүйжүүлэлт хийж хэрэглэнэ.

2.17. Сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхэд дамжуулан хэрэглэхгүй байхад анхаарч, хүүхэд бүрд хүртээмжтэй байхаар бэлтгэнэ.

2.18. Цэцэрлэгийн хөгжим, биеийн тамирын танхимыг шаардлагатай тохиолдолд бүлгийн зориулалтаар ашиглаж болно.

2.19. Дулааны улиралд хүүхдийн хөдөлгөөнийг дэмжих сургалт, үйл ажиллагааг гадна талбайд халдвараас сэргийлэх дэглэм баримтлан зохион байгуулж болно.

2.20. Цэцэрлэгийн хөгжим, хөдөлгөөн, эрүүл мэндийн танхимын сургалтыг тухайн бүлгийн багш зохион байгуулах бөгөөд хүүхэд ядрах, ачаалал авах, хөлрөх зэргээс сэргийлэн, хөдөлгөөний ачааллыг зохистой түвшинд байлгах, эрүүл мэндийг дэмжихэд чиглүүлэн зохион байгуулна.

2.20.1. журмын 2.20-д заасан сургалтыг жижиг бүлгээр болон ганцаарчилсан байдлаар хэрэглэгдэхүүн дамжуулахгүй байхаар зохион байгуулна.

2.21. Хөгжим, биеийн тамирын багш нь бүлгийн багшид сургалт, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, зайн сургалтыг зохион байгуулна.

Гурав. Эрсдэлээс сэргийлэх бэлэн байдлыг хангах

3.1. Цэцэрлэгийн орчинд коронавируст халдвар (КОВИД-19)-ын эрсдэлээс сэргийлэх, тандалт хийх, халдвар бүртгэгдсэн үед тархалтыг хязгаарлах болон орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, дотоод хяналтыг сайжруулах нэгдсэн удирдлагыг цэцэрлэгийн эрхлэгч хэрэгжүүлнэ.

3.2. Танхимын сургалт эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлан цэцэрлэгийн гадаад, дотоод орчинд цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт, агааржуулалтын хоолойд засвар үйлчилгээ хийж, анги танхимын бэлэн байдлыг хангана.

3.3. Цэцэрлэгийн байр болон нийтийн эзэмшлийн зам, талбайд зайн барих тэмдэг, тэмдэглэгээ заавал хийнэ.

3.4.Халдвартгүйжүүлэх уусмалыг хүрэлцээтэй байлгаж, цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлнэ.

3.5. Шаардлагатай цэг (ариун цэврийн өрөө, нийтийн эзэмшлийн талбай, гол тогоо, үүдний хэсэг, хүүхэд хүлээн авах өрөө, анги танхим бүрд, орох гарах хаалганы хажууд)-т амны хаалт зүүх, гар угаах, халдвартгуйжүүлэх санамж, зурагт хуудас, гар халдвартгуйжүүлэгч байршуулна.

3.6. Цэцэрлэгийн орчинд өдөр тутам цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлт хийхэд Улсын онцгой комиссын даргын 2021 оны А/41 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 3.2 дахь хэсгийг баримтална.

3.7. Ариун цэврийн өрөө, угаагуур, нүхэн жорлонд дараалал үүсгэхгүй байхаар зохицуулалт хийж, халдвартгуйжүүлэлт тогтмол хийнэ.

3.7.1. төвлөрсөн бус ус хангамжтай, нүхэн жорлонг ашигласны дараа багш, ажилтан спирт агуулсан гар халдвартгуйжүүлэгч хэрэглэх бөгөөд цэцэрлэгийн үүдний хэсэг, давхар бүрд гар халдвартгуйжүүлэгч уусмалыг байршуулна.

3.8. Цэцэрлэгийн барилга байгууламжид багш, ажилтан нэвтрэхэд Улсын онцгой комиссын даргын 2021 оны А/41 дугаар тушаалаар баталсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 2.1.1, 3.1.1, 3.1.2 дахь заалтын дагуу бүртгэл хөтөлнө.

3.9. Цэцэрлэгийн байранд багш, ажилтан, хүүхдийг амны хаалттай нэвтрүүлэх бөгөөд багш, ажилтан амны хаалтыг тогтмол зүүнэ. Хүүхэд анги танхимд амны хаалт хэрэглэхгүй.

3.10. Цэцэрлэгийн байр, анги танхимд гадны хүн нэвтрүүлэхийг хориглоно.

3.11. Багш, ажилтан, хүүхэд сургалт, үйл ажиллагааны үеэр ханиалгах, халуурах, хоолой өвдөх, амьсгал давчдах, амьсгалахад хүндрэлтэй болох, гүйлгэх, үнэрлэх, амтлах мэдрэмж алдагдах гэх зэрэг шинж тэмдэг илэрсэн үед анхны тусламж үзүүлэх түр тусгаарлах өрөөг бэлтгэнэ.

3.11.1. тусгаарлах өрөө нь нэгдүгээр давхарт байх бөгөөд гадагш гарахад хамгийн ойр, байгалийн агаар сэлгэлт хийх боломжтой байна.

3.11.2. тусгаарлах өрөөнд Улсын онцгой комиссын даргын 2021 оны А/41 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 2.1.8, 2.1.9-д заасан анхны тусламжийн иж бүрдэл, хамгаалах хувцас болон холбогдох бусад хэрэгслийг байршуулсан байна.

3.12. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан “Цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургууль, насан туршийн боловсролын төвийн багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах удирдамж”-ийн дагуу багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулна.

3.13. Хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг өрхийн эмнэлэг, эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулна.

3.14. Коронавируст халдварын эрсдэлээс сэргийлэх, хамгаалах дараах санамж, зөвлөмжийг боломжит бүх хэлбэрээр тодорхой давтамжтайгаар хүүхэд, багш, ажилтанд мэдээлэх, тэдгээрийг харагдахуйц газар байршуулан, дадал хэвшил болгох арга хэмжээ авна.

3.14.1. амны хаалт зөв хэрэглэх;

3.14.2. гарыг зөв угаах, халдвартгуйжүүлэх;

3.14.3. хүн хоорондын зай барих;

- 3.14.4. гараа нүд, ам, хамарт хүргэхгүй байх;
 - 3.14.5. гэр, анги, танхим, өрөө, тасалгаанд агаар сэлгэлт, цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлт хийх;
 - 3.14.6. сэжигтэй тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад хандах;
 - 3.14.7. халдвараар өвдсөн, ойрын хавьтал болсон тохиолдолд өөрийгөө тусгаарлах, эмчлүүлэх, дэглэм баримтлах;
 - 3.14.8. багш ажилтнууд коронавируст халдварын эсрэг вакцинд хамрагдах;
 - 3.14.9. хувийн ариун цэврийг сахих;
 - 3.14.10. сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгсэл, ном, тоглоом болон хувийн эд зүйлсийг өөр хоорондоо дамжуулан хэрэглэхгүй байх.
- 3.15. Хичээлийн жил эхлэхээс өмнө холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:
- 3.15.1. ундны усны шинжилгээ хийлгэж, хариу арга хэмжээ авах;
 - 3.15.2. шавж мэрэгчийн устгал, халдвартгуйжүүлэлт хийх.
- 3.16. Анги, танхим болон барилгын нийтийн эзэмшлийн талбайд салхивчаар агаар сэлгэлт хийх бэлэн байдлыг хангаж, салхивч болон ангийн хаалгыг аль болох нээлттэй байлгаж агаар сэлгэнэ.
- 3.16.1. цаг агаарын байдал, гаднах агаарын бохирдлоос шалтгаалан салхивч нээж анги танхимд агаар сэлгэлт хийх боломжгүй тохиолдолд агаар цэвэршүүлэгч (ХЕПА фильтр) ашиглаж болно.
- 3.17. Хүүхдийн гадуур хувцсыг цэцэрлэгт ирмэгц хувцасны уутанд хийж өлгөх зохицуулалт хийнэ.
- 3.18. Хүүхдийн шүдийг өглөө, оройд гэртээ сайтар угаалгаж, анgid угаахгүй байхаар зохицуулна.
- 3.19. Хүүхдийн ам, хоолойг хүнсний сод эсхүл давсны уусмалаар өглөө, өдөр оройд зайлуулж хэвшинэ.
- 3.20. Гар нүүрийн алчуурыг өдөр бүр сольж, цэвэр алчуур хэрэглэх нөхцөл, боломжоор хангана.
- 3.21. Хатуу, зөөлөн эдлэлд цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмжийн дагуу 7 хоног бүр хийнэ.
- 3.22. Цэцэрлэгийн байрны давхар болон жигүүр хооронд хөдөлгөөн хязгаарлах тэмдэг, тэмдэглэгээ хийж, хүүхэд, багш, ажилтны хөдөлгөөнийг байршилтай уялдуулан хянаж, бүртгэл хөтөлнө.
- 3.23. Анги танхимын ширээ, сандал, барилгын нийтийн эзэмшил газарт (хаалга, шатны бариул, гэрлийн унтраалга, сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, цонхны тавцан зэрэг хүний гар хүрэх бүх гадаргуу) цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлт хийх заавар, хуваарь, хяналтын хуудас гаргаж мөрдөх бөгөөд тэдгээрийн чанарт цэцэрлэгийн эмч, эмчгүй тохиолдолд дотоод хяналтын ажилтан өдөр бүр хяналт тавина.
- 3.24. Хүүхдийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд дараах шаардлага баримтална.
- 3.24.1. гаднаас хүлээн авч буй хүнсний түүхий эд, бараа, бүтээгдэхүүний хайрцаг, сав баглаа, боодлын гадаргууг сайтар арчиж цэвэрлэх, битүүмжлэлгүй

хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг угааж, цэвэрлэсний дараа агуулахад хадгалж хэрэглэнэ.

3.24.2. цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэглэл, аяга тавгийг зориулалтын шингэн, хүнсний содын уусмалаар угааж, цэвэрлэнэ.

3.24.3. бүлгийн хүүхдийн хэрэглэсэн аяга, таваг, халбагыг өөр хооронд нь солихгүй байх зохицуулалт хийнэ.

3.24.4. хүүхдэд цай/хоолны үйлчилгээ үзүүлэхэд түргэн гэмтэх болон даршилсан бүтээгдэхүүн, шарсан, хайрсан хоол хүнсийг хэрэглэхгүй бөгөөд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн шим тэжээллэг, амин дэмээр баялаг бүтээгдэхүүн, халуун ундаа хэрэглэнэ.

3.24.5. хүүхэд хооллох ширээг зйтай байрлуулан, нэг ширээнд цөөн хүүхэд суулгаж, өөр хоорондоо ярихгүй байх, аяга, таваг, халбагыг дамжуулан хэрэглэхгүй байх санамжийг хүүхдэд өгөх бөгөөд хоол, цайны үйлчилгээ бүрийн дараа ширээг халдвартгуйжүүлнэ.

3.24.6. хүүхдэд гэрээсээ уух, идэх зүйл, тоглоом авч ирэхгүй байх талаар багш, туслах багш эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөх бөгөөд авч ирсэн тохиолдолд оруулахгүй.

3.24.7. цэцэрлэгт багш, ажилтан, хүүхэд ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.

3.24.8. тусгай хэрэгцээ (залгих, зажлах бэрхшээлтэй, хүнсний харшил г.м) шаардлагатай хүүхдийн хоолны цэс төлөвлөлтийг эцэг эх, асран хамгаалагчтай зөвшилцэж, тэдний онцлогт нь тохирсон шим тэжээллэг хоолоор үйлчилнэ.

3.25. Хүүхдийг унтуулахад “толгой-хөл” зөрүүлэх зарчим баримтална.

3.26. Хүүхдийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг өдөр бүр цэвэрлэж, халдвартгуйжүүлэх ба угааж цэвэрлэх боломжгүй тоглоомыг ангид байлгахгүй.

3.27. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн таяг, түшүүр, тэргэнцрийн бариулын хэсгийг тогтмол халдвартгуйжүүлнэ.

3.28. Анги танхимаас гарсан хог хаягдал хийсэн уутны амыг боож, зөвшөөрөгдсөн цэгт хаяна.

3.29. Цэцэрлэгийн орчинд амны болон нүүрний хаалт, гар халдвартгуйжүүлэгч, бээлий, улавч зэргийг худалдан борлуулахыг хориглоно.

Дөрөв. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын тандалт, сэргийлэлт

4.1. Цэцэрлэгийн орчинд коронавируст халдвараас сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах багийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулна.

4.2. Энэ журмын 4.1-т заасан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1. цэцэрлэгийн байранд багш, ажилтан, хүүхдийг амны хаалттай нэвтрүүлэх, биеийн халууныг хэмжиж тэмдэглэл хөтлөх, гар халдвартгуйжүүлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулалтаар хангах;

4.2.2. хүүхэд, багш, ажилтан цэцэрлэгт нэвтрэхэд Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 3.1.2-т заасныг

хэрэгжүүлэх бөгөөд тандалтаар шинж тэмдэг илэрсэн тохиолдолд гэрт нь буцааж, эрүүл мэндийн байгууллагад хандахыг зөвлөнө.

4.2.3. хүүхэд, багш, ажилтны өдөр тутмын ирцийн болон эмнэл зүйн шинж тэмдгийн тандалт хийх;

4.2.4. танхимын сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн ирцийг тухайн өдрийн жижүүр багшаас авч, цэцэрлэгт ирээгүй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчтай холбогdon шалтгааныг тодруулах;

4.2.5. энэ журмын 4.2.3-т заасан ирцийн байдалд дүн шинжилгээ хийж, цэцэрлэгийн эрхлэгчид мэдээлэл өгөх, шаардлагатай тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;

4.2.6. сургалт, үйл ажиллагааны явцад коронавируст халдвартын эмнэл зүйн шинж тэмдэг (халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, үнэр, амт мэдрэхүй алдагдах, хамар битүүрэх, шингэн нусгоожих, амьсгаадах, дотор муухайрах, бөөлжих, суулгах зэрэг 3 болон түүнээс дээш) илэрсэн хүүхэд, багш, ажилтныг энэ журмын 3.11-д заасан өрөөнд тусгаарлан харьяа эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэх;

4.2.7. хүүхэд, багш ажилтныг коронавируст халдвараар өвдсэн эсэх тодруулга, судалгаа авах тохиолдолд нийтийн дунд зохион байгуулахгүй байх, авсан мэдээллийг нууцалж, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтад өртөхөөс сэргийлэх;

4.2.8. энэ журмын 5 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.

4.3. Энэ журмын 3.11-д заасан өрөөг халдвараас сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах багийн нэг гишүүн хариуцна.

Тав. Сэжигтэй тохиолдол бүртгэгдэх үед хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Сургалт, үйл ажиллагааны явцад хүүхдийн дунд энэ журмын 4.2.6-д заасан шинж тэмдэг илрэх тохиолдолд тухайн бүлгийн багш үүссэн нөхцөл байдлыг цэцэрлэгийн эмчид, эмчгүй тохиолдолд тусгаарлах өрөө хариуцсан ажилтанд яаралтай мэдэгдэнэ.

5.2. Цэцэрлэгийн орчинд коронавируст халдвартын сэжигтэй болон батлагдсан тохиолдол, ойрын хавьтал илэрвэл Улсын онцгой комиссын даргын 2021 оны А/41 дугаар тушаалаар баталсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 6.2-т заасан арга хэмжээг энэ журмын 4.1-д заасан баг хэрэгжүүлнэ.

Тайлбар: “Ойрын хавьтал” гэж батлагдсан тохиолдолтой эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 2 хоног, шинж тэмдэг илэрснээс хойш 1-14 хоногийн хугацаанд хавьтал болсон эсхүл лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан эмнэлзүйн шинж тэмдэггүй хүнтэй онош батлагдахаас өмнөх 2 хоног, батлагдснаас хойш 14 хоногийн хугацаанд хавьтал болсон хүнийг хэлнэ.

5.2.1. Дараах тохиолдолд ойрын хавьтал болсон гэж үзнэ:

5.2.1.1. коронавируст халдвартын батлагдсан хүнтэй 1.5-2 метрээс дотогш зайд 15 минут түүнээс дээш хугацаанд нүүр тулж харьцсан хүн;

5.2.1.2. нэг бүлэгт хамт байсан эсхүл нэг өрөөнд хамт амьдардаг, нэг ширээнд хамт хооллосон хүн;

5.2.1.3. хувийн болон нийтийн тээврийн хэрэгслээр 15 минутаас дээш хугацаагаар хамт зорчсон хүнийг.

5.3. Цэцэрлэгийн орчинд халдварын тохиолдол батлагдсан нөхцөлд тухайн бүлгийн өрөө, тасалгаа, давхарт голомтын халдвартгүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар яаралтай хийлгэнэ.

5.4. Ойрын хавьтлыг гэрийн тусгаарлалтад 7 хоногийн хугацаатай тусгаарлан ажиглана.

5.5. Ойрын хавьтлаар тусгаарлалтад байгаа хүүхэд, багш, ажилтанд батлагдсан зааврын дагуу тусгаарлалтын хугацаанд шинжилгээ авах ажлыг харьяа эрүүл мэндийн байгууллага хариуцна.

5.6. Энэ журмын 2.2-т заасан тохиолдлын улмаас танхимын бус (зайн) сургалтад шилжсэн бүлгийн хүүхэд, багш, ажилтныг б дахь хоногт коронавируст халдвар /КОВИД-19/ илрүүлэх бх-ПГУ шинжилгээнд хамруулах ажлыг харьяа эрүүл мэндийн байгууллага хариуцан зохион байгуулна.

5.6.1. Шинжилгээний хариу сөрөг гарсан хүүхэд, багш, ажилтныг цэцэрлэгийн танхимын сургалт, үйл ажиллагаанд оролцуулна.

Зургаа. Сургалт, үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг, оролцоо

6.1. Энэ журмын 3-т заасан үйл ажиллагаа бүрийг багш, ажилтан хариуцан гүйцэтгэх зохицуулалтыг дотоод хяналтын ажилтан хийж, цэцэрлэгийн эрхлэгчээр баталгаажуулан хэрэгжилтэд хяналт тавина.

6.2. Коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, ажлын байранд эерэг уур амьсгал бүрдүүлэх, айдас, түгшүүр, санаа зовнил, стресс бухимдлаас сэргийлэх талаар багш, ажилтанд сургалт зохион байгуулж, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.

6.2.1. энэ журмын 6.2-т заасан сургалтыг цэцэрлэгийн арга зүйч /эрхлэгч/ хариуцна.

6.3. Багш, ажилтан нь хүүхдийн хөгжлийн ялгаатай болон гэр бүлийн орчинд зайнаас суралцсан байдал, теле/цахим хичээл үзэх боломжгүй байсан нөхцөл зэргийг тус тус харгалзан хүүхэдтэй адил тэгш хүндэтгэлтэй эелдэг харилцах, тэдний сурах үйлийг дэмжин урам өгөх, ялгavarлан гадуурхах, нэр төрийг гутаах үйлдэл гаргахгүй багшийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллана.

6.4. Бүлгийн багш нь хүүхдэд халдвараас сэргийлэх, амны хаалтыг тогтмол зөв зүүх, хэрэглэсэн амны хаалтыг ил задгай хаяхгүй байх, гарсаа савандаж угаах (бохирдсон тухай бүр), зөв ханиаж найтаах (амаа гарын шууны дотор тал эсвэл тохойн дотор талаар халхлах, цаасан алчуураар ам, хамраа таглах, хэрэглэсэн цаасан алчуурыг хогийн саванд хийх), олон хүн цугларсан газар явахгүй байх зэрэг зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг хэрэгжүүлнэ.

6.5. Багш нь хүүхдэд эрүүл ахуйн зөв дадал хэвшил эзэмшүүлэх, дасгал хөдөлгөөн хийлгэх, стрессээс сэргийлэх, шим тэжээллэг хоол хүнс бэлтгэж өгөх зөвлөгөө, дэмжлэгийг эцэг эх, асран хамгаалагчдад үзүүлнэ.

6.6. Цэцэрлэгийн бүлгийн багш танхимаар болон зайнаас сургалт зохион байгуулах төлөвлөлтийг оновчтой хийж, хүүхэд болон эцэг эхэд аль болох нэмэлт ачаалал үүсгэхгүйгээр зохион байгуулах арга хэмжээ авах, энэ чиглэлээр багш нар мэргэжлийн бүлэгтэй хамтран ажиллана.

6.7. Багш, ажилтан, хүүхэд цэцэрлэгийн байранд орсон, гарсан болон анги танхим, цэцэрлэгийн барилгын нийтийн эзэмшлийн газраар явсан хөдөлгөөний

урсгалыг цаг хугацаагаар бүртгэж, дүн мэдээ гаргах ажлыг томилогдсон ажилтан хөтөлнө.

6.8. Анги танхимиын агаар сэлгэлт, гар халдвартгүйжүүлэх, амны хаалт зөв хэрэглэх болон багш, ажилтан тогтоосон цагт амны хаалт сольж байгаа эсэх, цэцэрлэгийн орчин дахь хөдөлгөөний урсгалын бүртгэл болон цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтэд хяналт тавих ажлыг дотоод хяналтын ажилтан хэрэгжүүлнэ.

6.9. Танхимаар хичээллэх үед хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчдад гарч болзошгүй айдас, түгшүүр, эргэлзээг тайлах, тайвшруулах нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг цэцэрлэгийн арга зүйч /эрхлэгч/ холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

6.10. Сургалт, үйл ажиллагааны үед багш, туслах багш, ажилтан амны эсхүл нүүрний хаалт тогтмол хэрэглэнэ. Хэрэглэсэн амны хаалт болон бусад бохир /ширээ, сандал, хичээлийн хэрэглэгдэхүүн болон гар арчсан цаас/-ыг тусгайлан бэлтгэсэн уут эсхүл тагтай хогийн саванд хийнэ.

6.11. Багш, ажилтан нь коронавируст халдвараас сэргийлэх дэглэмийг хүүхэд баримталж буй байдал болон тэдний эрүүл мэндийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд дотоод хяналтын ажилтанд мэдээлэл өгч ажиллана.

6.12. Коронавируст халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдол болон ойрын хавьтлаар тусгаарлагдсан багш, ажилтанд хүндэтгэлтэй хандах, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор ажил олгогчоос цалинтай чөлөө олгох асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

6.13. Багш, туслах багш нь хүүхэд өөр хоорондоо аяга, халбага, тоглоом, харандаа, ном, дэвтэр гэх мэт аливаа хэрэглэгдэхүүнийг дамжуулан хэрэглэхгүй байхад анхаарч, тогтмол хяналт тавьж, зөвлөж ажиллана.

6.14. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдэдээ амны хаалт (өглөө ирэх, орой тарах үед зүүхээр тооцох, хэт мэдрэг арьстай хүүхдэд тохирсон амны хаалт сонгох), гадуур хувцас хийх уут, амны хаалт хийх жижиг уут, бээлий (нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үед өмсөх) бэлтгэж өгнө.

6.15. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ биеийн байдлыг тогтмол ажиглаж, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд цэцэрлэгт явуулахгүй бөгөөд энэ талаар бүлгийн багшид мэдэгдэнэ.

6.16. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийг өглөө цэцэрлэгт ирэх, орой гэртээ харих үед амны хаалт зөв хэрэглүүлж хэвшүүлэх, “Гэр-цэцэрлэг-гэр” чиглэлийг мөрдөнө.

6.17. Гэр бүлийн орчинд зайн хэлбэрээр суралцах хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч багштай эргэх холбоотой ажиллах үүрэг хүлээнэ.

6.18. Коронавируст халдварын улмаас эмчлэгдэж эдгэрсэн хүүхэд, багш, ажилтан сургалт, үйл ажиллагаанд аливаа хязгаарлалтгүйгээр оролцно.

6.19. Хүүхдийг хүлээн авах, тарах үйл ажиллагааг бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулах бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч цэцэрлэгийн орох, гарах хаалгаар хүүхдээ хүлээлгэн өгч, авна. Энэ тохиолдолд хүн хоорондын зайн барих зөвлөмжийг мөрдөнө.

6.20. Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаатай холбогдох санал хүсэлт, гомдол мэдээлэл хүлээн авах, зөвлөгөө өгөх тусгай утсыг цэцэрлэг дээр ажиллуулах бөгөөд эрхлэгчийн баталсан хуваарийн дагуу тусгай утсыг арга зүйч эсхүл томилогдсон ажилтан хариуцан ажиллана.

6.21. Тусгай утасны дугаар болон ажиллах цагийн хуваарийн талаар эцэг эх, асран хамгаалагчид мэдээлнэ.

6.22. Эцэг эх, асран хамгаалагчийг цэцэрлэгт нэвтрүүлэхгүй бөгөөд сургалт, үйл ажиллагаатай холбогдох асуудлаар энэ журмын 6.21-т заасан утас болон цахимаар харилцана.

6.23. Үйлчилгээний ажилтан нь цэвэрлэгээ халдвартгуйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу тогтмол хийж, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шат болон хаалганы бариул, түшүүр, унтраалга зэрэг хүний гар хүрэх эд зүйлсийн гадаргууг 2 цаг тутам цэвэрлэж, халдвартгуйжүүлнэ.

6.24. Багш, ажилтан цэцэрлэгийн байрны давхар, жигүүр хооронд болон шаардлагагүй тохиолдолд хязгаарлалтын бүс дотор сэлгүүцэхийг хориглоно.

6.25. Эцэг эх, асран хамгаалагч хүүхдэдээ тоглоом, хүнсний бүтээгдэхүүн өгч явуулахыг хориглоно.

---000---

Боловсрол, шинжлэх ухааны сайд,
Эруул мэндийн сайдын 2021 оны
08 дугаар сарын 19 -ны өдрийн
~~А/292, А/525~~ дугаар хамтарсан
тушаалын хоёрдугаар хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ҮЕД
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
МӨРДӨХ ТҮР ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэ журмын зорилго нь коронавируст халдварт /КОВИД-19/-ын тархалтын түвшинтэй уялдуулан ерөнхий боловсролын сургууль /цаашид “сургууль” гэх-/ийн хичээл, сургалтыг зохион байгуулах, халдвараас сэргийлэх бэлэн байдлыг хангах, сургуулийн орчинд халдвартын сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдэх үед хариу арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хичээл, сургалтыг зохион байгуулахад Коронавируст халдварт /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Коронавируст халдварт /КОВИД-19/-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”, эрүүл мэндийн байгууллагаас гаргасан коронавируст халдвартын үед мөрдөх заавар, зөвлөмж болон энэхүү түр журмыг тус тус баримтална.

1.3. Хичээл, сургалтыг сургуулийн орчинд танхимаар зохион байгуулахад халдвараас сэргийлэх дэглээнийг чанд сахих, боловсролын үйлчилгээ тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах, багш, ажилтан-суралцагч, эцэг эх, асран хамгаалагч өөр хоорондоо харилцан хүндэтгэлтэй, эелдэг харилцах болон байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн нууцлалыг хадгалах зарчим баримтална.

1.4. Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулна.

Хоёр. Хичээл, сургалтын зохион байгуулалт

2.1. Хичээл, сургалтыг суралцагчийн сурлагын хоцрогдол нөхөх болон суралцах үйлийг дэмжихэд чиглүүлнэ.

2.2. Цар тахлын халдвартын тархалтын түвшнээс хамаарч хичээлийг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр зохион байгуулна.

2.2.1. Коронавируст халдвартын тархалтын ногоон болон шар түвшинд байгаа аймаг, сум, тосгон, багт байршилтай сургуулийн хичээлийг танхимаар зохион байгуулна.

2.2.2. Халдвартын тархалтын улбар шар болон улаан түвшинд байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэгт байршилтай сургуулийн суралцагч 5 өдөр танхимаар, 5 өдөр танхимын бус хэлбэр (зайн)-ээр тус тус хичээллэнэ.

2.3. Танхимын сургалтыг дараах тохиолдолд зогсоож, 7 хоногийн хугацаатай танхимын бус (зайн) сургалтад шилжинэ:

2.3.1.коронавируст халдварын эсрэг вакцинд хамрагдаагүй 12-оос доош насны хүүхэдтэй нэг бүлгээс халдварын тохиолдол батлагдах нөхцөлд тухайн бүлгийг;

2.3.2.коронавируст халдварын эсрэг вакцины бүрэн тунд хамрагдсан 12 ба түүнээс дээш насны хүүхэдтэй нэг бүлгийн 3 ба түүнээс дээш хүүхэд халдвар авсан тохиолдолд тухайн бүлгийг;

2.3.3.өөр хоорондоо хамааралгүй 3 болон түүнээс дээш анги, бүлэгт халдвар бүртгэгдсэн тохиолдолд тухайн давхар, хэсэг (жигүүр) эсхүл хичээлийн байранд (өвчлөл гарсан анги, бүлгийн байршил болон хичээлийн байраас хамаарч тухайн корпусыг хаах) хичээллэж байгаа анги бүлгийг;

2.3.4.өөр хоорондоо хамааралгүй (нэг жигүүр, нэг давхар биш, анги болон багш солигддоггүй) 3 ба түүнээс дээш анги, бүлгийн дотор халдварын тохиолдол батлагдсан нөхцөлд сургуулийг.

2.4.Танхимын ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа /цаашид “сургалтын цаг” гэх/ I-II анgid 30 минут, III-XII анgid 35 минут, бага, дунд, ахлах ангийн танхимын бус хичээл болон тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах үйлийг дэмжих ганцаарчилсан сургалтын үргэлжлэх хугацаа 20 минут байна.

2.5.Тусгай хэрэгцээт хүүхдийн суралцах үйлийг дэмжих ганцаарчилсан сургалтыг эцэг эх, асран хамгаалагч зөвшөөрсөн тохиолдолд танхимаар зохион байгуулна. Сургалтыг тухайн өдрийн хичээлийн дараа зохион байгуулна.

2.6.Бага ангийн суралцагч өдөрт сургалтын 4 цаг, дунд, ахлах ангийн суралцагч өдөрт сургалтын 5 цагаас илүүгүй хугацаанд танхимын сургалтад хамрагдана.

2.7.Танхимаар хичээллэх сургууль боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний 2019 оны A/491, A/511, 2020 оны A/37 дугаар тушаалын хавсралтаар баталсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэнэ.

2.8.Энэ журмын 2.2.2-т заасан танхим болон танхимын бус хосолсон хэлбэрээр хичээллэх сургууль Боловсролын хүрээлэнгээс хүргүүлсэн “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын хоцрогдол нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж”-ийг баримтална.

2.9.Танхимаар хичээллэх сургууль энэ журмын 2.7-д заасан сургалтын төлөвлөгөө болон Боловсролын хүрээлэнгээс хүргүүлсэн “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын хоцрогдол нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалт, үйл ажиллагааны удирдамж”-ийг баримтална.

2.10.Нэгдүгээр анги хичээлийн жилийн эхний гурван 7 хоногт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу бэлтгэл хөтөлбөр, дөрөв дэх 7 хоногоос эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байгаа сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэнэ.

2.11.Биеийн тамирын хичээлийг дулааны улиралд сургуулийн гадна талбайд тухайн өдрийн хичээлийн сүүлийн цагт зохион байгуулахаар зохицуулж, суралцагч хэт ядрах, ачаалал авах, хөлрөх зэргээс сэргийлж хурд, хүч шаардахгүй тэдний эрүүл мэндийг дэмжсэн хөнгөн дасгал, хөдөлгөөнийг хүн хоорондын зайд баримтлан хийлгэх, хөгжмийн хичээлийг хөгжим сонсгох үйлд тулгуурлан зохион байгуулна.

2.12.Суралцагч бие даан ажиллахад Боловсролын хүрээлэнгээс хүргүүлсэн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах дасгал ажлын дэвтрийг ашиглана.

2.13.Танхимын сургалт зохион байгуулахад мэргэжлийн байгууллагаас зөвшөөрсөн хүн хоорондын зайд баримтлах зөвлөмжийн дагуу ширээ хоорондын зайд 1-1.5м байх бөгөөд хичээллэх танхимын багтаамжаас хамаарч нэг анги, бүлэгт

хичээллэх хүүхдийн тоо 20 ± 5 байхаар тус тус тооцож анги, дэд бүлэг үүсгэх зохион байгуулалтыг хийнэ.

2.14. Бүлэг дүүргэлтийг 20 хүүхэдтэй зохион байгуулахад нэг ээлжээр хичээллэх боломжтой энэ журмын 2.2.2-т заасан халдвартын түвшинд байгаа аймаг, нийслэл, сум, дүүрэгт байршилтай сургууль нь эцэг эх, асран хамгаалагчийн санал, зөвшилцэл тэдэнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр танхимаар хичээллэж болно. Энэ тохиолдолд суралцагчийн танхимд хичээллэх хугацаа сургалтын 5 цагаас хэтрэхгүй байна.

2.14.1. Танхимаар хичээллэхийг эцэг эх, асран хамгаалагчаас зөвшөөрөөгүй тохиолдолд энэ журмын 2.2.2-т заасан хэлбэрээр хичээллэнэ.

2.15. Сургуулийн орчинд халдвартын тохиолдол бүртгэгдсэн нөхцөлд хичээлийг энэ журмын 2.3-т заасан сургалтын хэлбэрт шилжүүлнэ.

2.16. Энэ журмын 2.5-д заасан сургалт зохион байгуулахад суралцагчтай ойрын зайнаас харилцах, засан сайжруулах үйлчилгээний үед багш, ажилтан амны хаалт, нэг удаагийн бээлийн заавал хэрэглэж, тухай бүр солино.

2.17. Хичээл, сургалтын явцад хүүхдийн онцлог, хэрэгцээнээс хамаарч нүүрний хувирал, ам, уруулын хөдөлгөөн харуулах тохиолдолд багш, суралцагч амны хаалтыг авч нүүрний тунгалаг хаалт хэрэглэнэ.

2.18. Суралцагчдын бие даан гүйцэтгэх ажил, гэрийн даалгаврын хэмжээ, агуулга, хүндрэлийн түвшинг зохистой тогтоох, даалгаврын гүйцэтгэлээс шалтгаалан хүүхэд айдас түгшүүрт өртөж болзошгүй тул урьдчилан сэргийлэх арга хэмжээг заах аргын нэгдлийн ахлагч, нийгмийн ажилтан/сэтгэл зүйч авч хэрэгжүүлэх бөгөөд түүнд сургалтын менежер хяналт тавьж, хариу арга хэмжээ авна.

2.19. Энэ журмын 5.7, 6.21-д заасан тохиолдлын улмаас хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалтад байгаа суралцагчдын хичээлийг танхимын бус (зайн) хэлбэрээр үргэлжлүүлэх зохицуулалтыг сургалтын менежер хийж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.

2.20. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд ажиллах багшийн тоог хүчин төгөлдөр мөрдөж байгаа сургалтын төлөвлөгөөнд үндэслэн тогтоох бөгөөд сургалтын үйл ажиллагаа хэвийн горимоор хичээллэх үед багш илүүдэхгүй байхаар тооцно.

2.21. Сургууль хооронд багш солилцох болон цагийн багш ажиллуулахгүй бөгөөд цахим хичээлийг бүлэг, сургууль дундын хэлбэрээр зохион байгуулах зохицуулалт хийнэ.

2.22. Хичээл, сургалтын явцад нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон амьсгалын дутмагшилд орж болзошгүй суралцагчийн эрүүл мэндэд анхаарч, зовуурь, шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тухайн анgid хичээл зааж байгаа багш нь сургуулийн эмчид нэн даруй мэдэгдэнэ.

2.23. Танхимын сургалтын үед суралцагчдыг баг, бүлэг, хэсгээр ажиллуулах тохиолдолд хүн хоорондын зайд баримтлах дэглэм мөрдөнө.

2.24. Суралцагчийг эрэмбэлж ялгаа үүсгэсэн, суралцах хүсэл эрмэлзэл, сургалтын хэвийн үйл ажиллагааг бууруулсан аливаа үйл ажиллагаа зохион байгуулахгүй, мөн секц, дугуйлан хичээллүүлэхгүй.

2.25. Танхимын сургалтын үед кабинетын системээр хичээллэхгүй бөгөөд номын сан, хүүхэд хөгжлийн танхимыг сургалтын зориулалтаар ашиглаж болно.

2.26.Хичээлийн байранд бөөгнөрөл үүсэхээс сэргийлж хичээл эхлэх, завсарлах, дуусах цагийг анги бүлэг бүрд ялгаатай байхаар тогтоох, хичээлийн байранд орох, гарах боломжит бүх хаалгыг ашиглах зохицуулалт хийнэ.

2.27.Сургуулийн орчинд аливаа хурал, цуглаан зохион байгуулах тохиолдолд Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын “7. Соёл урлаг, сүм хийд, үзвэр үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээ, хурал цуглааны үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлага”-ын “ё/Хурал, цуглаан” хэсэгт заасныг мөрдөнө.

2.28.Багш, ажилтан, суралцагчийг хамарсан уралдаан, тэмцээн зохион байгуулахгүй.

Гурав. Эрсдэлээс сэргийлэх бэлэн байдлыг хангах

3.1.Сургуулийн орчинд коронавируст халдварт /КОВИД-19/-ын эрсдэлээс сэргийлэх, тандалт хийх, халдварт бүртгэгдсэн үед тархалтыг хязгаарлах болон орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, дотоод хяналтыг сайжруулах нэгдсэн удирдлагыг сургуулийн захирал хэрэгжүүлнэ.

3.2.Танхимиын сургалт эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлан сургуулийн гадаад, дотоод орчинд цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт, агаар сэлгэлтийн хоолой, төхөөрөмжид засвар үйлчилгээ хийж, анги танхимиын бэлэн байдлыг хангана.

3.3.Хичээлийн болон дотуур байрын нийтийн эзэмшлийн зам талбайд зайд барих тэмдэг, тэмдэглэгээг заавал хийнэ.

3.4.Гар угаах төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэн саван, гар халдвартгүйжүүлэгч хүрэлцээтэй байлгаж, цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлсэн байна.

3.5.Шаардлагатай цэг (нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, хувцас өлгөх болон хоол үйлдвэрлэх хэсэг, хурлын танхим, анги танхим бүрд, орох гарах хаалганы хажууд)-т амны хаалт зүүх, гар угаах, халдвартгүйжүүлэх санамж, зурагт хуудас, гар халдвартгүйжүүлэгч байршуулна.

3.6.Багш, ажилтан, суралцагч хичээл, сургалтын үеэр ханиалгах, халуурах, хоолой өвдөх, амьсгал давчдах, амьсгалахад хүндрэлтэй болох, гүйлгэх, үнэрлэх, амтлах мэдрэмж алдагдах гэх зэрэг шинж тэмдэг илэрсэн үед анхны тусламж үзүүлэх түр тусгаарлах өрөөг хичээлийн болон дотуур байранд бэлтгэнэ.

3.6.1.Тусгаарлах өрөө нь нэгдүгээр давхарт байх бөгөөд гадагш гарахад хамгийн ойр, байгалийн агаар сэлгэлт хийх боломжтой байна.

3.6.2.Тусгаарлах өрөөнд Улсын онцгой комиссын даргын 2021 оны А/41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 2.1.9-д заасан анхны тусламжийн иж бүрдэл, хамгаалах хувцас болон холбогдох бусад хэрэгслийг байршуулсан байна.

3.7.Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/145 дугаар тушаалаар баталсан “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-д заасны дагуу холбогдох багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан байна.

3.8.Сургуулийн барилга байгууламжид багш, ажилтан нэвтрэхэд Улсын онцгой комиссын даргын 2021 оны А/41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан

“Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 2.1.1, 3.1.1-д заасныг тус тус хэрэгжүүлнэ.

3.9. Коронавируст халдвартын эрсдэлээс сэргийлэх дараах санамж, зөвлөмжийг хичээл эхлэхийн өмнө болон хичээл хоорондын завсарлагааны хугацаанд боломжит бүх хэлбэрээр тодорхой давтамжтайгаар суралцагч, багш, ажилтанд мэдээлэх, тэдгээрийг харагдахуйц газарт байршуулж, дадал хэвшил болгох арга хэмжээ авна.

3.9.1.амны хаалт зөв хэрэглэх, 2 цаг тутам солих;

3.9.2.гарыг зөв угаах, халдвартгүйжүүлэх;

3.9.3.хүн хоорондын зайд барих;

3.9.4.гараа нүд, ам, хамарт хүргэхгүй байх;

3.9.5.агаар сэлгэлт, цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт хийх (гэр, анги танхим, өрөө, тасалгаа);

3.9.6.сэжигтэй тохиолдолд эрүүл мэндийн байгууллагад хандах;

3.9.7.коронавирусын халдварт авсан, ойрын хавьтал болсон тохиолдолд өөрийгөө тусгаарлах, эмчлүүлэх, дэглэм баримтлах;

3.9.8.коронавируст халдвартын эсрэг вакцинд хамрагдах;

3.9.9.хувийн ариун цэврийг сахих;

3.9.10.хичээлийн хэрэгсэл, ном, сурах бичиг болон хувийн эд зүйлсийг өөр хоорондоо дамжуулан хэрэглэхгүй байх.

3.10. Энэ журмын 3.9-т заасан санамж, зөвлөмжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэж мэдээлнэ.

3.11.Хичээлийн жил эхлэхээс өмнө холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.11.1.ундны усанд шинжилгээ хийлгэж, хариу арга хэмжээ авах;

3.11.2.шавж мэрэгчийн устгал, халдвартгүйжүүлэлт хийх.

3.12.Анги, танхим болон нийтийн эзэмшлийн талбайд салхивч /цонх/-аар агаар сэлгэлт хийх бэлэн байдлыг хангаж, хичээл хоорондын завсарлагаа бүрээр агаар сэлгэх, салхивч болон анги танхимиын хаалгыг аль болох нээлттэй хичээллэнэ.

3.12.1.Цаг агаарын байдал, гаднах агаарын бохирдлоос шалтгаалан салхивч нээж анги танхимд агаар сэлгэлт хийх боломжгүй тохиолдолд агаар цэвэршүүлэгч (ХЕПА фильтр) ашиглаж болно.

3.13.Дотуур байранд амьдардаг хүүхдийг эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэм баримтлан хүлээн авна.

3.13.1.Энэ журмын 3.2, 3.4, 3.5, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.11, 3.18, 3.22, 3.24, 3.28-д заасан арга хэмжээ болон халдвараас сэргийлэхэд баримтлах дэглэмийг дотуур байранд тус тус мөрдөнө.

3.13.2.Хүүхдийг унтуулахад “толгой-хөл” зөрүүлэх зарчим баримтална.

3.13.3.Хүүхдийн хоолойг сод эсхүл давсны уусмалаар өглөө, оройд зайлах боломжоор хангана.

3.13.4.Хатуу, зөөлөн эдлэлд цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын заавар, зөвлөмжийн дагуу 7 хоног бүр хийнэ.

3.14.Хичээлийн болон дотуур байрын давхар, хэсэг (жигүүр) хооронд хөдөлгөөн хязгаарлах тэмдэг, тэмдэглэгээ хийж, суралцагч, багш, ажилтны хөдөлгөөнийг байршилтай уялдуулан хянаж бүртгэл хөтөлнө.

3.15.Бага анги болон тусгай сургуулийн суралцагчдад үдийн цай/хоолны үйлчилгээг эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ангид зохион байгуулна. Хэрэв суралцагч хоол, цайны үйлчилгээ авахаас татгалзсан тохиолдолд энэ хугацаанд танхимаас түр гаргаж, нийтийн эзэмшийн талбайд хараа хяналттай байлгах зохицуулалт хийнэ.

3.16.Бага анги болон тусгай сургуулийн суралцагч, дотуур байранд амьдарч байгаа хүүхдэд үдийн цай/хоолны үйлчилгээ үзүүлэхэд түргэн гэмтэх, даршилсан бүтээгдэхүүн, шарсан, хайрсан хоол хүнс хэрэглэхгүй бөгөөд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан, хүүхдийн эрүүл мэндийг дэмжсэн шим тэжээллэг, амин дэмээр баялаг бүтээгдэхүүн, халуун ундаа хэрэглэнэ.

3.17.Суралцагчийн үдийн цай/хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн түлхүү хэрэглэнэ.

3.18.Тусгай хэрэгцээ (залгих, зажлах бэрхшээлтэй, хүнсний харшил гэх мэт) шаардлагатай хүүхдийн хоолны цэс төлөвлөлтийг эцэг эх, асран хамгаалагчтай зөвшилцөж, тэдний онцлогт тохирсон шим тэжээллэг хоолоор үйлчилнэ.

3.19.Үдийн цай/хоолыг битүүмжлэн анги бүлэгт хүргэж ирсэн ажилтан танхимд нэвтрэхгүй байхаар зохион байгуулна.

3.20.Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн хоолны үйлчилгээг заалаар зохион байгуулах бөгөөд энэ нөхцөлд Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын “2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлага”-ын хамаарах заалтыг баримтална.

3.20.1.Хоолны үйлчилгээг заалаар зохион байгуулахад давхар бүрийн хүүхдийг нэг ээлжид хамруулахаар зохицуулалт хийж, нэг ширээнд хүүхдийг өөдөөс нь харуулж суулгахгүй байх дэглэмийг мөрдөнө.

3.21.Энэ журмын 3.15, 3.20-д заасан үйлчилгээний үеэр өөр хоорондоо чанга ярихыг хориглох санамжийг суралцагчдад өгөх бөгөөд хоол, цайны үйлчилгээ бүрийн дараа ширээг халдвартгүйжүүлнэ.

3.22.Сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэглэл, аяга тавгийг хүнсний содын уусмал эсхүл зориулалтын шингэнээр угааж цэвэрлэнэ. Боломжтой тохиолдолд суралцагчдын хэрэглэсэн аяга, таваг, халбага, сэрээг өөр хооронд нь солихгүй байх зохицуулалт хийнэ.

3.23.Хичээлийн болон дотуур байранд багш, ажилтан, суралцагч ундны цэвэр ус уух боломжийг бүрдүүлнэ.

3.24.Анги танхимын ширээ, сандал, нийтийн эзэмшил газарт саван/угаалгын нунтаг, халдвартгүйжүүлэгч бодис (хаалга, шатны бариул, тушүүр, гэрлийн унтраалга, сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, цонхны тавцан зэрэг хүний гар хүрэх бүх гадаргуу болон агаар сэлгэлтийн хоолой)-оор цэвэрлэгээ хийх заавар, хуваарь, хяналтын хуудас гаргаж мөрдөх бөгөөд тэдгээрийн чанарт энэ журмын 6.9-д заасан ажилтан сургуулийн эмчтэй хамтран өдөр бүр хяналт тавина.

3.25.Сургуулийн орчинд өдөр тутам цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт хийхэд Улсын онцгой комиссын даргын 2021 оны А/41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 3.2 дахь хэсгийг баримтална.

3.25.1.Суралцагчдаар анги, танхимын өдөр тутмын цэвэрлэгээ хийлгэхгүй байхаар зохицуулалт хийнэ.

3.26.Харааны бэрхшээлтэй суралцагчийн сургалтад хэрэглэх брайль, самбар болон шивүүрийг 2 цаг тутам цэвэрлэж, халдвартгуйжүүлнэ.

3.27.Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн таяг, түшүүр, тэргэнцрийн бариулын хэсгийг 2 цаг тутам халдвартгуйжүүлэх уусмалаар цэвэрлэнэ.

3.28.Ариун цэврийн өрөө, угаагуур, нүхэн жорлонд дараалал үүсгэхгүй байхаар зохицуулалт хийж, цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлтийг 2 цаг тутамд хийнэ.

3.28.1.Төвлөрсөн бус ус хангамжтай тохиолдолд суралцагч, багш, ажилтан нүхэн жорлон ашигласны дараа спиртэн суурьтай гар халдвартгуйжүүлэгчээр гарыг цэвэрлэх бөгөөд сургуулийн үүдний хэсэг, давхар, анги бүрд гар халдвартгуйжүүлэгч уусмалыг хангалттай тоогоор байршуулна.

3.29.Ээлж бүрийн дараа анги танхимд салхивчаар агаар сэлгэлт хийх, чийгтэй цэвэрлэгээ, ширээний гадаргууг савангийн уусмал эсхүл спиртэн суурьтай халдвартгуйжүүлэгч уусмалаар арчина.

3.30.Сургууль нь хүүхэд тээвэрлэх автобусны үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт хамруулж, мэргэжлийн байгууллагаас зөвшөөрөл авсан байна.

3.30.1.Жолоочийн бүхээг нь зорчигчийн танхимаас тусгаарласан хаалттай байх бөгөөд халдвараас сэргийлэх санамж, зөвлөмж, амны хаалт болон гар халдвартгуйжүүлэгчийг тээврийн хэрэгсэлд тус тус байршуулна.

3.30.2.Тээврийн хэрэгсэлд хүн хоорондын зайд барих, эгнээ болон суудал алгасаж суулгах тэмдэглэгээ хийж мөрдөх, хамгийн сүүлд буух зорчигчийг арын суудалд суулгах зарчим баримтална. Нэг гэр бүлд хамт амьдардаг хүүхдийг зэргэлдээ суудалд хамт суулгаж болно.

3.30.3.Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах заавар, зөвлөмжийг тээвэрлэлтийн явцад тодорхой давтамжтайгаар зорчигчдод чанга яригчаар мэдээлэх арга хэмжээ авна.

3.30.4.Хүүхэд тээврийн хэрэгсэлд нэвтрэх үед амны хаалт зүүсэн эсэхэд жолооч хяналт тавьж, амны хаалтгүй тохиолдолд амны хаалтаар хангана.

3.30.5.Тээврийн хэрэгслийн цонхыг дулааны улиралд боломжит хэмжээгээр байнга нээлттэй байлгаж агаар сэлгэлт хийх ба энэ тохиолдолд зорчигчийн аюулгүй байдлыг сайтар хангана.

3.30.6.Зорчигч тээврийн хэрэгсэлд суухын өмнө болон бүрэн буусны дараа бүхээгийн бүх гадаргуу, салхины шил, зорчигчийн суудал, бариул болон хүний гар хүрэх хэсгийг цэвэрлэж халдвартгуйжүүлэлт, агаар сэлгэлт хийнэ.

3.31.Хичээлийн болон дотуур байранд гаднаас нэвтрүүлэх эд зүйлс, бараа материал, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний гадна сав, баглаа боодлыг зохих журмын дагуу халдвартгуйжүүлэлт хийнэ.

3.32.Суралцагчийн гадуур хувцас (пальто, куртка)-ыг хувцасны уутанд хийж өлгөх зохицуулалт хийнэ.

3.33.Хичээллэх танхимд орох, гаражад бөөгнөрөл үүсгэхгүй (тухайн суралцагчийг сургуулийн гадна ирсэн даруйд дотогш нэвтрүүлэх) байх зохицуулалт хийж, хөдөлгөөний чиглэл заасан зураглал гаргаж мөрдөнө.

3.34.Суралцагч, багш, ажилтнаас бусад хүнийг хичээлийн болон дотуур байранд нэвтрүүлэх, урлагийн танхим, спорт заалыг бусдад ашиглуулахыг тус тус хориглоно.

Дөрөв. Коронавируст халдварт /КОВИД-19/-ын тандалт, сэргийлэлт

4.1. Сургуулийн орчинд коронавируст халдвараас сэргийлэх, тандалт хийх, хариу арга хэмжээ авах багийг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй томилон ажиллуулна.

4.2. Энэ журмын 4.1-т заасан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.2.1. хичээлийн болон дотуур байранд багш, ажилтан, суралцагчийг амны хаалттай нэвтрүүлэх, биеийн халууныг хэмжиж тэмдэглэл хөтлөх, гар халдвартгүйжүүлэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулалтаар хангах;

4.2.2. суралцагч, багш, ажилтан сургуульд нэвтрэхэд Улсын онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 3.1.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд эцэг эх, асран хамгаалагчгүй бие даан ирсэн суралцагчийг энэ журмын 3.6-д заасан өрөөнд оруулж эцэг эх, асран хамгаалагчид нэн даруй мэдэгдэж хүлээлгэн өгөх;

4.2.3. суралцагч, багш, ажилтны өдөр тутмын ирц, эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийх;

4.2.4. танхимын сургалтад хамрагдаж байгаа суралцагчдын ирцийг тухайн өдрийн жижүүр багшаас авч, хичээлд ирээгүй суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчтай холбогдон шалтгааныг тодруулах;

4.2.5. энэ журмын 4.2.4-т заасан ирцийн байдалд дүн шинжилгээ хийж, сургуулийн захиралд мэдээлэл өгөх, шаардлагатай тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх;

4.2.6. хичээл, сургалтын явцад коронавируст халдварын эмнэлзүйн шинж тэмдэг (халуурах, ханиалгах, ядарч сульдах, толгой өвдөх, булчингаар өвдөх, хоолой өвдөх, үнэр, амт мэдрэхүй алдагдах, хамар битүүрэх, шингэн нус гоожих, амьсгаадах, дотор муухайрах, бөөлжих, суулгах зэрэг 3 болон түүнээс дээш) илэрсэн суралцагч, багш, ажилтныг энэ журмын 3.6-д заасан өрөөнд тусгаарлан харьяа эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэх;

4.2.7. коронавирусын халдварт авсан эсэх тодруулга, судалгааг суралцагчаас авах тохиолдолд анги нийтийн дунд зохион байгуулахгүй байх, авсан мэдээллийг нууцалж, аливаа байдлаар ялгаварлан гадуурхагдахаас сэргийлэх;

4.2.8. энэ журмын 5 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.

4.3. Тусгаарлах өрөөг энэ журмын 4.1-д заасан багийн нэг гишүүн хариуцна.

Тав. Сэжигтэй тохиолдол бүртгэгдэх үед хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Хичээл, сургалтын явцад суралцагчдын дунд энэ журмын 4.2.6-д заасан шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тухайн анги, бүлэгт хичээл зааж байгаа багш үүссэн нөхцөл байдлыг сургуулийн эмчид, эмчгүй тохиолдолд тусгаарлах өрөө хариуцсан ажилтанд яаралтай мэдэгдэнэ.

5.2. Энэ журмын 5.1-д заасан нөхцөл үүсэх тохиолдолд суралцагч, багш, ажилтныг анги танхимаас гаргахгүй салхивч /цонх/-ийг боломжит хэмжээгээр бүрэн нээж, өөр хоорондоо ярихгүй, тайван байхыг сануулж, сургууль дахь хөдөлгөөнийг бүрэн зогсоож, сургуулийн захирал харьяа эрүүл мэндийн байгууллагад яаралтай мэдэгдэнэ.

5.3. Сургуулийн орчинд коронавируст халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдол, ойрын хавьтал илэрвэл Улсын онцгой комиссын даргын 2021 оны А/41

дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдварт (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах түр журам”-ын 6.2-т заасан арга хэмжээг энэ журмын 4.1-д заасан баг хэрэгжүүлнэ.

5.3.1. Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлыг тогтоох судалгааг энэ журмын 4.1-д заасан баг, сургуулийн эмчгүй тохиолдолд харьяа эрүүл мэндийн байгууллага тус тус хийнэ.

Тайлбар: “Ойрын хавьтал” гэж батлагдсан тохиолдолтой эмнэлзүйн шинж тэмдэг илрэхээс өмнөх 2 хоног, шинж тэмдэг илэрснээс хойш 1-14 хоногийн хугацаанд хавьтал болсон эсхүл лабораторийн шинжилгээгээр онош батлагдсан эмнэлзүйн шинж тэмдэггүй хүнтэй онош батлагдахаас өмнөх 2 хоног, батлагдснаас хойш 14 хоногийн хугацаанд хавьтал болсон хүнийг хэлнэ.

5.3.2. Дараах тохиолдолд ойрын хавьтал болсон гэж үзнэ:

5.3.2.1.коронавируст халдвартын батлагдсан хүнтэй 1.5-2 метрээс дотогш зайд 15 минут түүнээс дээш хугацаанд нүүр тулж харьцсан хүн;

5.3.2.2.нэг анги, бүлэгт хамт байсан эсхүл нэг өрөөнд хамт амьдардаг, нэг ширээнд хамт хооллосон хүн;

5.3.2.3.сургуулийн автобус, хувийн болон нийтийн тээврийн хэрэгслээр 15 минутаас дээш хугацаагаар хамт зорчсон хүнийг.

5.4.Дотуур байранд амьдардаг хүүхдийн дунд халдвартын сэжигтэй тохиолдол, ойрын хавьтал бүртгэгдсэн нөхцөлд тэднийг тусгаарлан халдвараас сэргийлэх дэглэм баримталж, харьяа эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

5.5.Дотуур байранд халдвартын сэжигтэй, батлагдсан тохиолдол, ойрын хавьтал бүртгэгдсэн нөхцөлд нэг өрөөнд хамт амьдардаг хүүхдийн цай, хоолыг өрөөнд нь өгөх бөгөөд тэдний хэрэглэсэн аяга, таваг, халбага, сэрээг тусад нь угааж халдваргүйжүүлнэ.

5.6.Сургуулийн орчинд халдвартын тохиолдол батлагдсан нөхцөлд тухайн анги танхим, өрөө, тасалгаа, давхарт голомтын эцсийн халдвартгүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар яаралтай хийлгэнэ.

5.7.Ойрын хавьтлыг гэрийн тусгаарлалтад 7 хоногийн хугацаатай шилжүүлэх, дотуур байранд амьдардаг хүүхдээс ойрын хавьтал болсон тохиолдлыг дотуур байранд тусад нь өрөөнд 7 хоногийн хугацаанд тусгаарлан ажиглана.

5.8.Ойрын хавьтлыг 6 дахь хоногт лабораторийн шинжилгээнд хамруулна.

5.9. Энэ журмын 2.3-т заасан тохиолдлын улмаас танхимиын бус (зайн) сургалтад шилжсэн анги бүлгийн суралцагч, сургуулийн багш, ажилтныг 6 дахь хоногт коронавируст халдварт /КОВИД-19/ илрүүлэх бх-ПГУ шинжилгээнд хамруулах ажлыг харьяа эрүүл мэндийн байгууллага хариуцан зохион байгуулна.

5.9.1.Шинжилгээний хариу сөрөг гарсан суралцагч, багш, ажилтныг танхимиын хичээл, сургалтын үйл ажиллагаанд оролцуулна.

Зургаа. Хичээл, сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын үүрэг, оролцоо

6.1.Энэ журмын 3-т заасан үйл ажиллагаа бүрийг багш, ажилтнаар хариуцуулах зохицуулалтыг дотоод хяналтын ажилтан хийж, сургуулийн захирлаар баталгаажуулан хэрэгжилтэд хяналт тавина.

6.2.Коронавируст халдвараас сэргийлэх, бэлэн байдлыг хангах, ажлын байранд эерэг уур амьсгал бүрдүүлэх, айдас, түгшүүр, санаа зовнил, стресс

бухимдлаас сэргийлэх талаар багш, ажилтанд хичээл эхлэхээс өмнө сургалт зохион байгуулж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлнэ.

6.2.1.Энэ журмын 6.2-т заасан сургалтыг сургалтын менежер хариуцна.

6.3.Сургууль завсардахаас сэргийлэх зорилгоор танхимын сургалт эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө суралцагч, тэдний эцэг эх, асран хамгаалагчтай холбоо тогтоох, суралцагч танхимын сургалтад хамрагдах эсхүл гэр бүлийн орчинд зайнаас суралцах эсэхийг тус тус тандан судлах ажлыг сургуулийн захиргаанаас зохион байгуулна.

6.3.1.Энэ журмын 6.3-т заасан тандалтын дүнд үндэслэн суралцагчийн суралцах хэлбэрийг "танхимын" эсхүл "танхимын болон танхимын бус хосолсон (5 хоног танхим, 5 хоног зайн)", эсхүл "танхимын бус (зайн)" гэсэн ангиллаар сургалтын менежер боловсролын салбарын мэдээллийн системд тус тус бүртгэнэ.

6.4.Багш, ажилтан нь суралцагчийн хөгжлийн ялгаатай болон гэр бүлийн орчинд зайнаас суралцсан байдал, теле/цахим хичээл үзэх боломжгүй байсан нөхцөл зэргийг тус тус харгалзан суралцагчтай адил тэгш хүндэтгэлтэй зелдэг харилцах, тэдний сурах үйлийг дэмжин урам өгөх, ялгаварлан гадуурхах, нэр төрийг гутаах үйлдэл гаргахгүй байх, багшийн ёс зүйн хэм хэмжээг мөрдөх ажиллана.

6.5.Анги удирдсан багш нь суралцагчдад халдвараас сэргийлэх, амны хаалт тогтмол зөв зүүх, хэрэглэсэн амны хаалтыг тагтай хогийн саванд хаях, гараа савандаж угаах (хооллохын өмнө болон дараа заавал гар угаах), өөр хоорондоо 1.5 метрээс багагүй зайнаас харьцах, зөв ханиаж найтаах (амаа гарын шууны дотор тал эсвэл тохойн дотор талаар халхлах, цаасан алчуураар ам, хамраа таглах, хэрэглэсэн цаасан алчуурыг хогийн саванд хийх), агаар сэлгэлт хийх, олон хүн цугларсан газар явахгүй байх, коронавируст халдвараар өвдөөд эдгэрсэн хүнтэй харилцах нь аюулгүй, вирусийн халдвартыг дамжуулахгүй тул тэднийг ялгаварлан гадуурхах үйлдэл гаргахгүй байх зэрэг зөвлөгөө, мэдээлэл өгөх, тэдгээрийг дадал хэвшил болгох ажлыг хэрэгжүүлнэ.

6.5.1.Амны хаалт хэрэглэх явцад амьсгал давчдах, амьсгалахад хүндрэл үүсэх, дотор муухайрах, бие тавгүйтэх зэрэг шинж тэмдэг илрэх тохиолдолд хичээл зааж байгаа багшид яаралтай хэлэх талаар анги удирдсан багш нь суралцагчдаа тогтмол сануулна.

6.6.Суралцагчдын онцлогт тохирсон эрүүл ахуйн боловсрол, зөв дадал хэвшил олгох, шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх, дасгал хөдөлгөөн хийх, стрессээс сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг эрүүл мэнд, биеийн тамирын болон тухайн хичээл зааж байгаа багш нар хичээл эхлэхийн өмнө суралцагчдад хүргэх ажлыг зохион байгуулна.

6.7.Сургалтын менежер танхимаар болон танхимын бус (зайн) хэлбэрээр хичээл, сургалт зохион байгуулах хуваарийг оновчтой зохицуулж, өдөрт тухайн анги, бүлэгт олон багш орохгүй байх зохицуулалт хийх, нэг мэргэжлийн багш нар хамтран хичээлд бэлтгэх, багшийн ачааллыг тэнцвэртэй, нэмэлт ачаалал үүсгэхгүйгээр зохион байгуулах арга хэмжээ авах, энэ чиглэлээр багш нар, мэргэжлийн бүлэгтэй хамтран ажиллана.

6.8.Багш, ажилтан, суралцагч хичээлийн болон дотуур байранд орсон, гарсан болон анги танхим, нийтийн эзэмшлийн газраар явсан хөдөлгөөний урсгалыг цаг хугацаагаар бүртгэж, дүн мэдээ гаргах ажлыг давхар бүрд томилогдсон багш, ажилтан хөтөлнө.

6.9.Анги танхимын агаар сэлгэлт, гар халдвартайжүүлэх, амны хаалт зөв хэрэглэх болон тогтоосон цагт амны хаалт сольж байгаа эсэх, сургуулийн орчин

дахь хөдөлгөөний урсгалын бүртгэл болон цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлтэд хяналт тавих ажлыг дотоод хяналтын ажилтан хэрэгжүүлнэ.

6.10.Дотуур байрын өрөө, тасалгаанд цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэлт хийх ажлыг дотуур байрын багш удирдан зохион байгуулж, агаар сэлгэлт хийх, эрүүл ахуйн дэглэм баримтлах, хүүхдийн эрүүл мэндийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд сургуулийн эмчид мэдэгдэж, зөвлөгөө авч ажиллана.

6.11.Танхимаар хичээллэх үед суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад гарч болзошгүй айdas, түгшүүр, эргэлзээг тайлах, тайвшруулах нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг нийгмийн ажилтан/сэтгэл зүйч холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

6.12.Хичээл, сургалтын үйл ажиллагааны үед суралцагч, багш, ажилтан амны эсхүл нүүрний хаалт тогтмол хэрэглэнэ. Хэрэглэсэн амны хаалт болон бусад бохир (ширээ, сандал, хичээлийн хэрэглэгдэхүүн болон гар арсан цаас)-ыг тусгайлан бэлтгэсэн уут эсхүл тагтай хогийн саванд хийнэ.

6.13.Багш, ажилтан нь коронавируст халдвараас сэргийлэх дэглэмийг суралцагчид баримталж буй байдал болон тэдний эрүүл мэндийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд дотоод хяналтын ажилтанд мэдээлэл өгч ажиллана.

6.14.Бага анги болон тусгай сургуулийн суралцагч, дотуур байранд амьдарч байгаа хүүхдэд үдийн цай/хоолоор үйлчлэх ажилтан нэг удаагийн бээлий, амны эсхүл нүүрний хаалт тогтмол хэрэглэнэ.

6.15.Багш, ажилтан, суралцагч хичээлийн болон дотуур байранд ундны цэвэр ус уух нөхцөлд өөрсдийн аяга, усны савтай байна.

6.16.Коронавируст халдварын сэжигтэй, батлагдсан тохиолдол болон ойрын хавьтлаар тусгаарлагдсан багш, ажилтанд хүндэтгэлтэй хандах, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор ажил олгогчоос цалинтай чөлөө олгох эсэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна.

6.17.Коронавируст халдварын улмаас эмчлэгдэж эдгэрсэн суралцагч, багш, ажилтан хичээл, сургалтын үйл ажиллагаанд аливаа хязгаарлалтгүйгээр орно.

6.18.Суралцагч энэ журмын 3.9-д заасан халдвараас сэргийлэх санамж, зөвлөмжийг чанд баримталж, өөрийгөө болон бусдыг эрсдэлээс хамгаалах бөгөөд хичээлийн явцад хуваарилсан суудалд сууж, суудал солихгүйгээр хичээллэнэ.

6.19.Суралцагч бал үзэг, цаас, ном дэвтэр, гар утас гэх зэрэг хэрэглэгдэхүүн болон гэрээсээ бэлтгэж ирсэн ус, ундааны зүйл, хүнсний бүтээгдэхүүнийг өөр хоорондоо дамжуулан хэрэглэхийг хориглоно.

6.20.Эцэг эх, асран хамгаалагч хүүхдэдээ халдвараас сэргийлэх санамж, зөвлөмжийг сайн мөрдөх талаар байнга сануулах, амны хаалт (2 цаг тутамд солихоор тооцох, хэт мэдрэг арьстай хүүхдэд тохирсон амны хаалт сонгох), нойтон салфетка, спиртэн суурьтай гар халдвартгуйжүүлэгч, гадуур хувцас хийх уут, хэрэглэсэн салфетка, амны хаалт хийх жижиг уут бэлтгэж өгнө. Хичээлд ирэхээс өмнө хүүхдэд цай, хоол заавал идүүлсэн байна.

6.21.Эцэг эх, асран хамгаалагч хүүхдийнхээ биеийн байдлыг тогтмол ажиглаж, өвдсөн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд хичээлд явуулахгүй бөгөөд энэ талаар анги удирдсан багшид заавал мэдэгдэнэ. Хүүхдийнхээ танхимиын хичээлийн хуваарьтай танилцаж, “Гэр-сургууль-гэр” гэсэн чиглэлийг мөрдүүлнэ.

6.22.Гэр булийн орчинд зайн хэлбэрээр суралцах суралцагч болон тэдний эцэг эх, асран хамгаалагч нь багштай эргэх холбоотой ажиллаж хүүхдийнхээ сурах үйлд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

6.23. Эцэг эх, асран хамгаалагчийг сургуульд нэвтрүүлэхгүй бөгөөд хичээл, сургалтын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар энэ журмын 6.25-д заасан утас болон цахимаар харилцана.

6.24. Суралцагчийг хүлээн авах, тарах үйл ажиллагааг бөөгнөрөл үүсгэхгүйгээр зохион байгуулах бөгөөд эцэг эх, асран хамгаалагч сургуулийн орох, гарах хаалгаар хүүхдээ хүлээлгэн өгч, авна. Энэ тохиолдолд хүн хоорондын зайд барих зөвлөмжийг мөрдөнө.

6.25. Хичээл, сургалтын ажилтай холбогдох санал хүсэлт, гомдол мэдээлэл хүлээн авах, зөвлөгөө өгөх тусгай утас, цахим шуудан сургууль дээр ажиллуулах бөгөөд тусгай утсыг захирлын баталсан хуваарийн дагуу багш, ажилтан хариуцан ажиллана.

6.25.1. Тусгай утасны дугаар болон ажиллах цагийн хуваарийн талаар эцэг эх, асран хамгаалагчид мэдээлнэ.

6.26. Үйлчилгээний ажилтан нь цэвэрлэгээ халдвартгүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу тогтмол хийж, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шат болон хаалганы бариул, түшүүр, унтраалга зэрэг хүний гар хүрэх эд зүйлсийн гадаргууг 2 цаг тутам халдвартгүйжүүлэх уусмалаар шүршиж, арчин халдвартгүйжүүлнэ.

6.27. Анги танхимаас гарсан хог хаягдал хийсэн уутны амыг боож зөвшөөрөгдсөн цэгт хаяна.

6.28. Багш, ажилтан, суралцагч хичээлийн байрны давхар хооронд болон шаардлагагүй тохиолдолд хязгаарлалтын бүс дотор сэлгүүцэхийг хориглоно.